



## НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 10 өдөр

Дугаар A/168

Улаанбаатар хот

Г

### Газар эзэмших эрх олгох тухай

Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, 2020 оны 152 дугаар тогтоол, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны А/40 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Газар эзэмшүүлэх эрхийн нээлттэй дуудлага худалдаанд оролцож ялагчаар шалгарсан 6 (Зургаан) иргэн, аж ахуйн нэгжид газар эзэмших эрх олон хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмших эрх олгогдсон иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, гэрчилгээ олон, Улсын бүртгэлд бүртгэж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд даалгасугай.

3. Холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж, газрыг зориулалтын дагуу зөв зохистой эзэмшихийг хавсралтад нэр заагдсан иргэн, аж ахуйн нэгжид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД